

МУИС-ИЙН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО	БАРИМТ БИЧГИЙН № NUM/EOMS/FMT/17
	ХУВИЛБАР №01
	БОЛОВСРУУЛСАН ОГНОО: 2025 он

МУИС-ИЙН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

МУИС-ийн бодлого нь алсын хараа, эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд найдвартай, өндөр чанартай боловсрол, сургалт, судалгаа болон бусад үйлчилгээгээр сонирхогч, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангаж, үндэсний хэмжээнд баталгаажсан байр сууриа бэхжүүлэн, олон улсад өрсөлдөх чадвараа тасралтгүй үнэлж сайжруулахад чиглэнэ.

МУИС нь оюутан, багш, ажил олгогч, үйлдвэрлэл эрхлэгч, төрийн байгууллага, олон нийтийн нийтлэг хэрэгцээ, хүлээлтэд байнга анхаарч, холбогдох бүх шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна боловсролын байгууллагын менежментийн тогтолцоогоо байнга сайжруулж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж, оюуны өмчийг эрхэмлэн ажиллана.

МУИС-ийн боловсролын бодлого дараах чиглэлд төвлөрнө:

- Боловсролын инновацыг ашиглан оюутнуудад үндэсний болон олон улсын түвшинд өрсөлдөхүйц, өндөр чанартай, өргөн цар хүрээтэй мэдлэг, эрдмийн зэрэг эзэмших боломж бүрдүүлнэ;
- Үйл ажиллагаагаа төлөвлөх, удирдах, хэрэгжүүлэх бүх шатанд оюутан болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангана;
- Нийгэм, эдийн засгийн тэргүүлэх зорилгод нийцсэн боловсролын үйлчилгээгээр нийгэмд үр өгөөжөө хүргэнэ;
- Оролцогч талуудын идэвхтэй оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж мэргэжилтнүүдэд тасралтгүй боловсрол олгоно;
- Олон улсын дээд боловсролын зах зээлд өрсөлдөх чадвараа бэхжүүлнэ;
- Багш, ажилтнуудаа тогтвортой ажлын байр, аюулгүй эрүүл орчин, мэргэжлийн хөгжлийн боломжуудаар хангана;
- Ёс зүйд нийцээгүй аливаа үйл ажиллагааг хориглон, эрдэм шинжилгээний бүрэн бүтэн байдал, эрдмийн эрх чөлөөг хамгаална;
- Бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчинэ.